



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/227

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Дайчилгааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн 2025 оны улсын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг ханган мэдээлэл, аюулгүй байдлыг чанд сахин ажиллахыг Цэргийн штаб (Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай.


3.Дайчилгааны төлөвлөгөөний төслийг боловсруулан нийслэлийн Засаг даргаар батлуулах ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
Ажлын хэсгийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:
Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын дарга
Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн
хэлтсийн дарга,
Засаг даргын тамгын газрын Хотын стандарт,
тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс дарга
Засаг даргын тамгын газрын Хүнс, худалдаа,
үйлчилгээний хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга
Боловсролын хэлтсийн дарга
Татварын хэлтсийн дарга
Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Эрүүл мэндийн төвийн дарга
91 дүгээр сургуулийн захирал
94 дүгээр сургуулийн захирал
Багахангайн тохижилт ОНӨААТҮГ-ийн захирал
Илч-Орд ОНӨААТҮГ-ийн захирал
Ус суваг ашиглалтын товчооны дарга
Налайх эрчим хүчний салбарын
Өндөртолгой хэсгийн мастер
Статистикийн ахлах мэргэжилтэн
1 дүгээр хорооны Засаг дарга
2 дугаар хорооны Засаг дарга

Нарийн бичиг:

Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн
сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн,
улсын дайчилгааны асуудал хариуцсан ажилтан